



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: А.Сувдаа

Утас: 70342495

Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 162

танай _____ ны № _____ т

БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.БАЛДАНДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Тайлант онд дотоод албан томилолтоор ажилласан нийт 24 хүнд 640.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон,
- 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр албан томилолтын урьдчилгаа авсан 400.0 мянган төгрөгийг олгосон ч суутган тооцоогүй,
- Ажилчдад нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан цагаас хэтрүүлж нийт 1132.6 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү тооцож олгосон,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс цэцэрлэгийн эрхлэгч нарт туршлага судлахад 10100.0, ЗДТГ-ын албан хаагчдад магистрын сургалтын төлбөрийн дэмжлэг 2500.0, Ачуут морин спорт, уяачдын холбооны хаврын морин уралдаанд

632502588

дэмжлэг 5000.0 мянган төгрөг зэрэг зардлууд гарч, хөрөнгийг зориулалт бус зарцуулах эрсдэлтэй,

- ЗДТГ-ын арилжааны банканд дахь дансаар 23,945.8, нийгмийн бодлогын мэргэжилтний дансаар 17,395.0, нярвын дансаар 10,060.0, хөдөлмөр хамгааллын мэргэжилтний дансаар 3264.5 мянган төгрөгийн бэлнээр авч зарцуулсан
- Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс БТСГ-ын 100 жилд дэмжлэг 1000.0, Булган дэд станцын 40 жил 500.0, Тохижилт үйлчилгээний ангийн 15 жилд 3,000.0, Статистикийн байгууллагын 100 жилд 5,00.0 нийт 5,000.0 мянган төгрөгийг дэмжлэг олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, дугаар зүйлийн 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.4, 25.4.1, 25.4.2, НББ-ийн тухай хуулийн дугаар зүйлийн 5.1, дугаар зүйлийн 6.1, 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4, 72.5.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Булган сумын ЗДТГ нь чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээг авч 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “КВ СЕРТФ” ХХК баталгаажуулалтын хорооны тогтоолоор гэрчилгээ авсан байна.

Аудитын гол асуудал

Тайланд онд Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 64.9 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Булган сумын ЗДТГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 141 арга хэмжээг төлөвлөснөөс хэрэгжилтийг 96.1 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>63,059,772.00</u>	<u>209,358,610.55</u>
33	АВЛАГА	855,000.00	94,766,134.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	855,000.00	500,381.05
335	Бусад авлага	-	94,265,753.50
3351	Байгууллагаас авах авлага	-	94,265,753.50
35	БАРАА МАТЕРИАЛ	62,204,772.00	89,952,476.00
351	Түүхий эд материал	19,105,600.00	29,651,600.00
35110	Тусгай зориулалттай материал	19,105,600.00	29,651,600.00
354	Хангамжийн материал	43,099,172.00	60,300,876.00
35410	Бичиг хэргийн материал	6,404,345.00	3,298,645.00
35420	Аж ахуйн материал	18,526,208.00	24,220,152.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,154,000.00	6,568,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	4,441,560.00
35450	Барилгын засварын материал	2,960,859.00	8,077,959.00
35470	Бусад хангамжийн материал	8,053,760.00	13,694,560.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	24,640,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	24,640,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,941,462,367.99</u>	<u>4,045,197,127.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,941,462,367.99	4,045,197,127.10
392	Биет хөрөнгө	3,148,800,932.16	3,253,060,691.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,138,479,759.83	3,302,509,683.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(514,086,557.57)	(748,547,408.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117,994,800.00	165,934,690.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,151,823.21)	(35,713,283.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,047,293.75	274,997,677.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,148,713.58)	(44,008,131.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,390,647.00	108,349,578.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,305,890.66)	(36,348,467.86)
39209	Зам, гүүрийн байгууламж	104,207,690.80	131,251,190.80
39210	Хуримтлагдсан элэгдэл	(53,191,542.12)	(63,081,656.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	289,523,530.86	301,523,530.86
39215	Хуримтлагдсан элэгдэл	(65,958,262.94)	(103,806,711.17)
393	Биет бус хөрөнгө	792,661,435.83	792,136,435.71
39301	Програм хангамж	4,650,000.00	4,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,128,750.17)	(2,653,750.29)
39303	Бусад биет бус хөрөнгө	790,140,186.00	790,140,186.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,004,522,139.99</u>	<u>4,254,555,737.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,470,820.34</u>	<u>13,219,282.13</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,470,820.34	13,219,282.13

413	Өглөг	4,470,820.34	13,219,282.13
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	748,461.79
4136	Бусад өглөг	4,470,820.34	12,470,820.34
41361	Байгууллагад төлөх өглөг	4,470,820.34	12,470,820.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,000,051,319.57	4,241,336,455.52
51	Засгийн газрын хувь оролцоо	4,000,051,319.57	4,241,336,455.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	603,075,965.00	603,075,965.08
512	Хуримтлагдсан үр дүн	3,135,361,200.42	3,376,646,336.29
51210	Өмнөх үеийн үр дүн	3,135,361,200.42	3,142,564,094.89
51220	Тайлант үеийн үр дүн	-	234,082,241.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261,614,154.15	261,614,154.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,004,522,139.91	4,254,555,737.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төг
рөгө
өр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,887,746,426.00	4,453,799,830.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	510,342,724.00	258,541,828.01
120	Нийтлэг татварын бус орлого	510,342,724.00	258,541,828.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	510,342,724.00	258,541,828.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,487,650.00	17,731,623.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	489,855,074.00	240,810,205.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,377,403,702.00	4,195,258,002.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	667,975,802.00	372,708,602.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,769,554.00	36,702,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	559,206,248.00	336,006,202.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,709,427,900.00	3,822,549,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,709,427,900.00	3,822,549,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,379,757,713.48	4,029,981,045.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,379,757,713.48	3,447,993,995.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,311,546,493.70	3,132,983,555.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		

		969,017,898.88	1,496,967,804.74
210101	Үндсэн цалин	487,956,474.66	769,433,837.00
210102	Нэмэгдэл	282,971,261.98	585,988,545.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,093,464.85	55,355,000.00
210104	Урамшуулал	44,193,734.30	56,775,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	108,802,963.09	29,414,522.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,237,287.05	187,768,494.90
210201	Тэтгэврийн даатгал	75,225,908.49	126,658,130.04
210202	Тэтгэмжийн даатгал	8,803,426.12	15,219,602.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,047,047.26	9,440,148.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,707,171.79	7,290,122.81
210205	Эрүүл мэндийн даатгал	17,453,733.39	29,160,490.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,989,558.65	222,964,600.62
210301	Гэрэл, цахилгаан	22,057,013.04	23,179,198.72
210302	Түлш, халаалт	188,866,818.90	192,946,976.84
210303	Цэвэр, бохир ус	11,065,726.71	6,838,425.06
2104	Хангамж, бараа материалын зардал	36,145,866.99	64,425,704.00
210401	Бичиг хэрэг	3,965,500.00	12,422,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,268,238.99	42,769,158.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,697,790.00	5,261,896.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,810,100.00	3,028,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,404,238.00	943,100.00
2105	Нормативт зардал	1,593,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,593,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,602,985.00	135,939,010.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	3,104,000.00
210604	Урсгал засвар	50,162,985.00	132,835,010.00
2107	Томилолт, зочны зардал	5,479,000.00	19,635,160.00
210701	Гадаад албан томилолт	-	7,995,860.00
210702	Дотоод албан томилолт	5,479,000.00	11,639,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	711,298,252.64	429,864,018.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	709,636,752.64	428,361,836.00
210803	Даатгалын үйлчилгээ	238,000.00	738,600.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,500.00	227,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	76,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	-
210807	Газрын төлбөр	650,000.00	460,032.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,182,644.49	575,418,763.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,333,740.00	221,273,509.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,756,100.00	7,165,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,092,804.49	346,980,254.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,211,219.78	315,010,440.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,029,500.00	79,419,393.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,000,000.00	20,000,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	27,196,893.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,029,500.00	32,222,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,181,719.78	235,591,047.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,181,719.78	235,591,047.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	581,987,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	581,987,050.00
223001	Бусад хөрөнгө	-	581,987,050.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	507,988,712.52	423,818,784.24
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	189,736,542.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	138,787,542.84
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	50,949,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(189,736,542.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	507,988,712.52	234,082,241.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,397,891,352.00	4,212,989,625.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,487,650.00	17,731,623.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,487,650.00	17,731,623.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,487,650.00	17,731,623.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,487,650.00	17,731,623.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,377,403,702.00	4,195,258,002.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	667,975,802.00	372,708,602.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,769,554.00	36,702,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	559,206,248.00	336,006,202.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,709,427,900.00	3,822,549,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,709,427,900.00	3,822,549,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,315,847,852.00	3,166,766,130.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,315,847,852.00	3,166,766,130.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,249,856,632.22	2,851,150,690.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	969,872,898.88	1,492,758,198.37
210101	Үндсэн цалин	488,811,474.66	718,224,121.25
210102	Нэмэгдэл	282,971,261.98	617,389,638.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,093,464.85	65,335,000.00
210104	Урамшуулал	44,193,734.30	54,568,138.43
210105	Гэрээт ажлын хөлс	108,802,963.09	37,241,300.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,237,287.05	186,823,598.06
210201	Тэтгэврийн даатгал	75,225,908.49	127,040,099.49
210202	Тэтгэмжийн даатгал	8,803,426.12	14,945,899.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,047,047.26	7,472,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,707,171.79	7,472,899.68
210205	Эрүүл мэндийн даатгал	17,453,733.39	29,891,799.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,989,558.65	222,964,600.62
210301	Гэрэл, цахилгаан	22,057,013.04	23,179,198.72
210302	Түлш, халаалт	188,866,818.90	192,946,976.84
210303	Цэвэр, бохир ус		

		11,065,726.71	6,838,425.06
2104	Хангамж, бараа материалын зардал	38,151,737.00	51,067,534.00
210401	Бичиг хэрэг	5,650,000.00	6,440,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,398,259.00	32,799,938.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,697,790.00	6,319,996.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,605,800.00	4,199,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,799,888.00	1,308,000.00
2105	Нормативт зардал	5,400,000.00	11,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,400,000.00	11,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,835,300.00	131,708,120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	4,661,400.00
210604	Урсгал засвар	46,335,300.00	127,046,720.00
2107	Томилолт, зочны зардал	5,479,000.00	19,635,160.00
210701	Гадаад албан томилолт	-	7,995,860.00
210702	Дотоод албан томилолт	5,479,000.00	11,639,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	714,389,102.64	522,471,075.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	712,727,602.64	520,968,893.00
210803	Даатгалын үйлчилгээ	238,000.00	738,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,500.00	227,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	76,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	-
210807	Газрын төлбөр	650,000.00	460,032.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,501,748.00	211,972,404.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	133,885,848.00	204,097,404.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,615,900.00	7,875,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,991,219.78	315,615,440.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,809,500.00	80,024,393.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,000,000.00	20,000,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	27,196,893.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,809,500.00	32,827,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,181,719.78	235,591,047.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,181,719.78	235,591,047.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	82,043,500.00	1,046,223,494.50

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	82,043,500.00	1,046,223,494.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,043,500.00	1,046,223,494.50
2200	Дотоод эх үүсвэрээр	82,043,500.00	1,046,223,494.50
222001	Тоног төхөөрөмж	33,513,500.00	145,039,600.00
223001	Бусад хөрөнгө	48,530,000.00	901,183,894.50
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(82,043,500.00)	(1,046,223,494.50)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	300,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	603,075,965.08	261,614,154.15	2,627,672,487.90	3,492,362,607.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	603,075,965.08	261,614,154.15	2,627,372,487.90	3,492,062,607.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	507,988,712.52	507,988,712.52
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	603,075,965.08	261,614,154.15	3,135,361,200.42	4,000,051,319.65
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	603,075,965.08	261,614,154.15	3,135,361,200.42	4,000,051,319.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,202,894.47	7,202,894.47
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	603,075,965.08	261,614,154.15	3,142,564,094.89	4,007,254,214.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	234,082,241.40	234,082,241.40
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	603,075,965.08	261,614,154.15	3,376,646,336.29	4,241,336,455.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3837549400.00	3607470485.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2736660300.00	2561246991.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2657963400.00	2483222598.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1494589900.00	1492758198.37
210101	Үндсэн цалин	747479500.00	718224121.25
210102	Нэмэгдэл	617510400.00	617389638.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64000000.00	65335000.00
210104	Урамшуулал	65600000.00	54568138.43
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	37241300.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186823600.00	186823598.06
210201	Тэтгэврийн даатгал	127040100.00	127040099.49
210202	Тэтгэмжийн даатгал	14945900.00	14945899.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	7472900.00	7472900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7472900.00	7472899.68
210205	Эрүүл мэндийн даатгал	29891800.00	29891799.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231218800.00	222964600.62
210301	Гэрэл, цахилгаан	23000000.00	23179198.72
210302	Түлш, халаалт	193218800.00	192946976.84
210303	Цэвэр, бохир ус	15000000.00	6838425.06
2104	Хангамж, бараа материалын зардал	51560000.00	51067534.00
210401	Бичиг хэрэг	6440000.00	6440000.00
210402	Тээвэр, шатахуун	32800000.00	32799938.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,320,000.00	6,319,996.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,200,000.00	4,199,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,308,000.00
2105	Нормативт зардал	11,750,000.00	11,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,750,000.00	11,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	225,546,800.00	131,708,120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	98,500,000.00	4,661,400.00
210604	Урсгал засвар	127,046,800.00	127,046,720.00
2107	Томиллолт, зочны зардал	19,900,000.00	19,635,160.00
210701	Гадаад албан томиллолт	8,000,000.00	7,995,860.00
210702	Дотоод албан томиллолт	11,900,000.00	11,639,300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,579,800.00	155,466,433.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,779,000.00	153,964,251.00
210803	Даатгалын үйлчилгээ	738,600.00	738,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,200.00	227,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	76,000.00
210807	Газрын төлбөр	650,000.00	460,032.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	273,994,500.00	211,048,954.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,994,500.00	203,173,954.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	7,875,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,696,900.00	78,024,393.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,696,900.00	78,024,393.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,000,000.00	20,000,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,196,900.00	27,196,893.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,500,000.00	30,827,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,100,889,100.00	1,046,223,494.50
2200	Дотоод эх үүсвэрээр	1,100,889,100.00	1,046,223,494.50
222001	Тоног төхөөрөмж	-	145,039,600.00
223001	Бусад хөрөнгө	1,100,889,100.00	901,183,894.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,000,000.00	3,840,281,023.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	3,822,549,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	3,822,549,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	17,731,623.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55.00	55.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55.00	55.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	27.00	27.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	369,928,092.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	369,928,092.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	367,928,092.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	367,004,642.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	367,004,642.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	923,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	923,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	372,708,602.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	372,708,602.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	36,702,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	336,006,202.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 547,511.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг эхний хагас жилээс хойш байгуулаагүй, үр дүнгийн тайланд 168,751,212 төгрөгөөр дутуу тусгасан байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 56,275.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авах зардалд тусгаагүй, бусдаар гүйцэтгүүлэх зардлыг 58,378.9 төгрөгөөр дутуу, бараа үйлчилгээний зардлыг 56,611.1 төгрөгөөр илүү тусгасан,
- Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 5,499.8 илүү, НДШ зардлыг 2,609.1 төгрөгөөр дутуу, урсгал засварын зардлыг 39,708.3 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
- Үндсэн хөрөнгийн тайлангийн барилга байгууламжийн данснаас шилжүүлсэн хөрөнгийг 99,111.1 мянган төгрөгөөр дутуу,
- Бараа материалын тайланд үнэ төлбөргүй шилжүүлсэн 50,949.0 мянган төгрөгийн хөрөнгийн зарлагыг дутуу тусгасан, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлогыг 9,618.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.

Аудитаар нийт 79,437.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2172.6 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 72,265.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 5000.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 79437.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс Их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

- Тайлант онд дотоод албан томилолтоор ажилласан нийт 24 хүнд 640,000.0 (зургаан зуун дөчин мянган) төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Ажилчдад нэмэгдэл хөлс олгоходоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан цагаас хэтрүүлж нийт 1,132,579.00 (нэг сая нэг зуун гучин хоёр мянга таван зуун далан есөн) төгрөгийн нэмэгдэл хөлс илүү тооцож олгосон

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалттай нийцээгүй байна.

- 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр албан томилолтын урьдчилгаа 400,000.00

(дөрвөн зуун мянган) төгрөгийг олгосон ч суутган тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

- Засаг даргын нөөц хөрөнгөөс цэцэрлэгийн эрхлэгч нарт туршлага судлахад 10,000,000.00 (арван сая), ЗДТГ-ын албан хаагчдад магистрын сургалтын төлбөрийн дэмжлэг 2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган), Ачуут морин спорт, уяачдын холбооны хаврын морин уралдаанд дэмжлэг 5,000,000.00 (таван сая) төгрөг зэрэг зардлууд гарч, хөрөнгийг зориулалт бус зарцуулах эрсдэл байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 4.1-д "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна." 5.2-д "Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна." гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

- ЗДТГ-ын арилжааны банканд дахь дансаар 23,945,798.00 (хорин гурван сая есөн зуун дөчин таван мянга долоон зуун ерэн найман), нийгмийн бодлогын мэргэжилтний дансаар 17,395,000.00 (арван долоон мянга гурван зуун ерэн таван), нярвын дансаар 10,060,000.00 (арван сая жаран мянган), хөдөлмөр хамгааллын мэргэжилтний дансаар 3264500.00 (гурван сая хоёр зуун жаран дөрвөн мянга таван зуун) төгрөгийн бэлнээр авч зарцуулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.3-д "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна." гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Зөвлөмж:

Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт 1: Байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй томилохдоо санхүүгийн, эд хариуцагч нарыг оруулж томилсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх; 72.5.1-д тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах; 73.2-д Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор

бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг хийх комисст эд хариуцагч нарыг оруулахгүй, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх

Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт 3: Бараа материалын тайланд түүвэр хийхэд бичиг хэргийн материалын нярвын тайланд 1 сарын тайланд 2023 оны шаардах хуудас 5 ш, 5 сарын тайланд 1 дүгээр сарын 4 ширхэг, 3 дугаар сарын 1 ширхэг, 4 дүгээр сарын 11 ширхэг, 6 дугаар сарын 1 ширхэг шаардах хуудсаар зарлага гаргаж нярвын тайлан хийсэн

НББ-ийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:" 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно

Зөвлөмж: Хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлт бүрийг тухай бүр нь хийж байх.

Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт 2: Байгууллагын нягтлан бодогч Э.Анхчимэгийг 2024.04.30-ны Б/35 тушаалаар ажлаас чөлөөлж, У.Ундармааг томилсон, мөн нярваар түр ажиллаж байсан Г.Номнинг 2024.12.02-ны Б/83 дугаар тушаалаар чөлөөлж, хүүхэд харах чөлөөтэй байсан Д.Золзаяаг эргүүлэн томилсон байна. Эд хариуцагч, эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгийн тооллого хийгээгүй

Зөвлөмж: Хагас жилийн хөрөнгийн тооллогыг чанартай хийж, үлдэгдлийг баталгаажуулан, үр дүнг тооцох.

Зардлын данстай холбоотой

Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс БТСГ-ын 100 жилд дэмжлэг 1000.0, Булган дэд станцын 40 жил 500.0, Тохижилт үйлчилгээний ангийн 15 жилд 3000.0, Статистикийн байгууллагын 100 жилд 500.0 нийт 5000.0 сая төгрөгийг дэмжлэг олгосон

Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 25.4-д "Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно: 25.4.1-д "санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх;" 25.4.2-д "байгууллагын хүний нөөцийн чадвхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийг үр ашигтай байх чиглэлд анхаарах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Үндсэн хөрөнгийн элэгдлийг эхний хагас жилээс хойш байгууллаагүй, үр дүнгийн тайланд 168,751,212 төгрөгөөр дутуу тусгасан байна.	1	168,751.0			1	168751	1	168751	0.0	0.0	0.0
Мөнгөн гүйлгээний тайланд худлдан авсан хөрөнгийн 56,275,000 төгрөгийн хөрөнгө худалдан авах зардалд тусгаагүй, бусдаар гүйцэтгүүлэх зардлыг 58378998 төгрөгөөр дутуу тусгасан, бараа үйлчилгээний зардлыг 56611108 төгрөгөөр илүү тусгасан,	1	171,265.1			1	171,265.1	1	171,265.1			
Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 5499850 илүү, НДШ зардлыг 2609075 төгрөгөөр дутуу, урсгал засварын зардлыг 39708300 төгрөгөөр дутуу тусгасан	1	47,817.2			1	47,817.2	1	47,817.2			
Үндсэн хөрөнгийн тайлангийн барилга байгууламжийн данснаас шилжүүлсэн хөрөнгийг 99,111,058 төгрөгөөр дутуу,	1	99111.1	1	99111.1			1	99111.1			
Бараа материалын тайланд үнэ төлбөргүй шилжүүлсэн 50949000 төгрөгийн хөрөнгийн зарлагыг дутуу тусгасан, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлогыг 9618000 төгрөгөөр дутуу тусгасан байна.	1	60567.0	1	60567.0			1	60567.0			
Дүн	5	547,511.6	2	159678.1	3	387833.5	5	547,511.6			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд дотоод албан томилолтоор ажилласан нийт 24 хүнд 640000.0 төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон	1	640	1	640								
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр албан томилолтын урьдчилгаа авсан 400000.0 төгрөгийг олгосон ч суутган тооцоогүй	1	400	1	400								
Ажилчдад нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан цагаас хэтрүүлж нийт 1132579.0 төгрөгийн нэмэгдэл хөлс илүү тооцож олгосон	1	1132.6	1	1132.6								
Засаг даргын нөөц хөрөнгөөс цэцэрлэгийн эрхлэгч нарт туршлага судлахад 10.0, ЗДТГ-ын албан хаагчдад магистрын сургалтын төлбөрийн дэмжлэг 2500.0, Ачуут морин спорт, уяачдын холбооны хаврын морин уралдаанд дэмжлэг 5000.0 мянган төгрөг зэрэг зардлууд гарч, хөрөнгийг зориулалт бус зарцуулах эрсдэл	1	17000.0			1	17000.0						

ЗДТГ-ын арилжааны банканд дахь дансаар 23,945,798, нийгмийн бодлогын мэргэжилтний дансаар 17,395,000, нярвын дансаар 10,060,000, хөдөлмөр хамгааллын мэргэжилтний дансаар 3264500 төгрөгийн бэлнээр авч зарцуулсан	1	54665.3			1	54665.3						
Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс БТСГ-ын 100 жилд дэмжлэг 1000.0, Булган дэд станцын 40 жил 500.0, Тохижилт үйлчилгээний ангийн 15 жилд 3000.0, Статистикийн байгууллагын 100 жилд 500.0 нийт 5000.0 сая төгрөгийг дэмжлэг олгосон	1	5000					1	5000				
Бараа материалын тайланд түүвэр хийхэд бичиг хэргийн материалын нярвын тайланд 1 сарын тайланд 2023 оны шаардах хуудас 5 ш, 5 сарын тайланд 1 дүгээр сарын 4 ширхэг, 3 дугаар сарын 1 ширхэг, 4 дүгээр сарын 11 ширхэг, 6 дугаар сарын 1 ширхэг шаардах хуудсаар зарлага гаргаж нярвын тайлан хийсэн	1						1					
Байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй томилохдоо санхүүгийн, эд хариуцагч нарыг оруулж томилсон	1						1					
Байгууллагын нягтлан бодогч Э.Анхчимэгийг 2024.04.30-ны Б/35 тушаалаар ажлаас чөлөөлж, У.Ундармааг томилсон, мөн нярваар түр ажиллаж байсан Г.Номнинг 2024.12.02-ны Б/83 дугаар тушаалаар чөлөөлж, хүүхэд харах чөлөөтэй байсан Д.Золзаяаг эргүүлэн томилсон байна. Эд хариуцагч, эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгийн тооллого хийгээгүй	1						1					

ДҮН	9	79437.9	3	2172.6	2	72265.3	4	5000				
-----	---	---------	---	--------	---	---------	---	------	--	--	--	--

-oOo-